



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 15

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.в, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Боловсролын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14,830,354 /арван дөрвөн сая найман зуун гучин мянга гурван зуун тавин дөрөв/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн хөрөнгийг хавсралт 1-ийн дагуу акталж үнэлгээ тогтоон худалдах, 19,145,280 /арван есөн сая нэг зуун дөчин таван мянга хоёр зуун ная/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн УБХ 26-62 улсын дугаартай Land Cruiser 80 маркын автомашиныг хавсралт 2-ын дагуу аклан дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, ОНӨА-ны хяналтан дор зохион байгуулж, актлагдсан болон дуудлага худалдаагаар худалдагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Боловсролын газрын дарга Ц.Бумангэрэлд даалгасугай.

3. Дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг 5,000,000/таван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ




0100039

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 7 сарын
13 өдрийн 15-р тогтоолын хавсралт 1

Акталж устгах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Ашиглалтанд орсон он	Үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Касио хөгжим	1	2002	542,700.0	542,700.0	542,700.0	-
2	Өнгөт ТВ	1	1997	235,531.8	235,531.8	235,531.8	-
3	Өсгөгч	1	1997	361,800.0	361,800.0	361,800.0	-
4	Dell ком процессор	1	2004	1,260,650.0	1,260,650.0	1,260,650.0	-
5	Проектор	1	2006	2,952,585.9	2,952,585.9	2,952,585.9	-
6	Нөүтбүүк	1	2005	2,089,990.0	2,089,990.0	2,089,990.0	-
7	Тог баригч	1	2005	81,895.0	81,895.0	81,895.0	-
8	Тог баригч	1	2005	105,450.0	105,450.0	105,450.0	-
9	Athena процессор	1	2007	1,114,042.8	1,114,042.8	1,114,042.8	-
10	Кадоскоп	1	2002	1,334,228.0	1,334,228.0	1,334,228.0	-
11	Sharp хөгжим	1	2002	274,081.6	274,081.6	274,081.6	-
12	Ком процессор LG	1	2003	725,400.0	725,400.0	725,400.0	-
13	Процессор LG	1	2002	776,400.0	776,400.0	776,400.0	-
14	Сапон 25 скайнер	1	2007	87,301.5	87,301.5	87,301.5	-
15	Факсын аппарат	1	2003	281,862.1	281,862.1	281,862.1	-
16	LBR-810 принтер	1	2004	455,144.9	455,144.9	455,144.9	-
17	LBR-2900 принтер	1	2004	424,615.0	424,615.0	424,615.0	-
18	Зургийн аппарат	1	2000	219,988.0	219,988.0	219,988.0	-
19	Хөргөгч	1	1980	379,890.0	379,890.0	379,890.0	-
20	Кабинетийн ширээ	6	2002	63,315.0	379,890.0	379,890.0	-
21	Саңдал	13	2002	27,135.0	352,755.0	352,755.0	-
22	Самбар ногоон	1	2002	356,298.8	356,298.8	356,298.8	-
23	Сэтгүүлийн ширээ	1	1998	10,854.0	10,854.0	10,854.0	-
Нийт дүн					14,803,354.4	14,803,354.4	-

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 07 сарын
13 өдрийн 15-р тогтоолын хавсралт 2



Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө

№	Хөрөнгийн нэр	Ашигалт анд орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Хуригтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдааны үнийн доод санал
1	Land автомашин	2007	1	19,145,280	19,145,280	19,145,280	-	5,000,000
	ДҮН				19,145,280	19,145,280	-	5,000,000